

# ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2022 – 05 САР | ДУГААР 42

## ГАРЧИГ

- 2–4 Бодлогын нийтлэл
- 4–7 Зохицуулалтын мэдээ
- 8–9 Байр суурь
- 10 Уур амьсгалын өөрчлөлт ба унадаг дугуйн хэрэглээ
- 11–13 2022 оны финтекийн 10 тренд
- 14–16 Судлаачийн индэр
- 17–18 Санхүүгийн боловсрол /Хадгаламж, зээлийн хоршоо гэж юу вэ?/
- 19 Санхүүгийн тооцоололд суралцъя
- 20–21 Компанийн засаглал
- 22–23 Олон улсын зах зээлийн мэдээ
- 24 Олон улсын хөрөнгийн зах индекс

## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА УНАДАГ ДУГУЙН ХЭРЭГЛЭЭ



Ногоон эдийн засаг нь байгалийн нөөцийг зохистой түвшинд ашиглан түүнийг тэгш хүртээмжтэйгээр хуваарилах агуулгаараа хүрэн эдийн засгаас ялгаатай. Улаанбаатар хот дахь агаарын бохирдлын улмаас өвлийн улиралд ханиад томуу ихсэж, замын түгжрэлээс улбаатай бидний үнэ цэнэтэй цаг хугацаа замд өнгөрч байгааг харах харамсалтай.

Улаанбаатар хот дахь автотээврийн хэрэгслийн ачааллын талаарх энгийн тоо баримтаас дурдахад, Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээ 1,564.1 мянган км<sup>2</sup> ба улсын нийслэл маань үүний ердөө 0.3 хувь буюу 4.7 мянган км<sup>2</sup> нутаг дэвсгэрт оршдог. Харин Монгол улсын өрхийн тоо 920,165 байдгаас Улаанбаатар хотод 55.2 хувь буюу 412,527 өрх, гэр бүл амьдардаг. Харин нийт автотээврийн хэрэгслийн 53.9 хувь буюу 618,475 нь Улаанбаатар хотод зорчдог суудлын, ачааны автомашин болон мотоцикл байгаа нь нэг өрхөд ойролцоогоор 2 автомашин ногдож байгааг харуулж байна. Улаанбаатар хот дахь тээврийн хэрэгслийн тоо жилд дунджаар

7.5 хувиар өсдөг нь өрхийн тооны дундаж өсөлтөөс мөн хувиар өндөр байгаа нь цаашдын төлөв танд төсөөлөгдөж байгаа байх.

Ажлын таван өдрийн турш замын түгжрэлд 20 цагийг өнгөрөөх, олон нийтийн баяр ёслол, хичээлийн шинэ жил ойртох үеийн амралтын өдрүүдийн түгжрэлд бид юу алдаж буй талаар та бодож байсан уу? Өнөөгийн Улаанбаатар хотын нөхцөлд таны тээврийн хэрэгслээ унах сонголтод төлөгдөж буй үнэ цэнэтэй цаг хугацаа, шатахууны зардал, түүнээс үүсэх нүүрсхүчлийн хий, хөдөлгөөний дутмагшил нь бидний эрүүл мэндийг хохироож байдаг.

Нөгөө талаасаа автомашины хэрэглээ нь байгаль орчинд нүүрсхүчлийн хий ялгаруулж, озоны давхаргыг нимгэрэхэд хүргэдэг ба судалгаагаар нэг галлон бензин зарцуулахад 8,887 грамм, нэг галлон дизелээс 10,180 грамм нүүрсхүчлийн хий ялгардаг талаар тооцоолол гарсан. Зорчигч автотээврийн хэрэгслээр нэг милл буюу 1.6 км явахад 404 грамм, жилд 4.6 метр.тонн нүүрсхүчлийн хий ялгарахад нөлөөлдөг байна.



Үргэлжлэл 10-р нүүрт



## ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

### ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА

Энэхүү харьцаа нь компанийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг харуулдаг. Эргэлтийн хөрөнгөнөөс үндсэн хөрөнгийг хасаж өр төлбөрт харьцуулдаг.



### QUICK RATIO /LIQUID RATIO/

A ratio used for assessing the liquidity of a company; it is the ratio of the liquid assets (i.e the current asset less the stock) to the current liabilities.

Эх сурвалж:  
Банк санхүүгийн тайлбар толь бичиг



## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА



Сүүлийн жилүүдэд блокчэйн технологийн тусламжтайгаар уламжлалт санхүүгийн зах зээл хувьсан өөрчлөгдөж, цаашид хөгжих, улам боловсронгуй болох эхлэл бий болсон. Нөгөөтээгүүр, блокчэйн технологи нь төвлөрсөн бус зах зээлд дундын зуучлалгүй, нэрийн нууцлалтай гүйлгээ хийх боломж бий болгосон нь аливаа төрлийн гэмт хэргийн мөнгө дамжих эрсдэлтэй тул дэлхий дахинд виртуал хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчныг бүрдүүлж, зохицуулалтыг тодорхойлох шаардлага үүссэн.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-аас гаргасан олон улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 зөвлөмжийн Зөвлөмж 15 / шинэ технологид/-д улс орнууд виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарын

тусгайлсан бодлого зохицуулалтыг бий болгох, хяналт тавих шаардлагатай гэж заасан. Хэдийгээр Монгол Улс нь 2020 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсын жагсаалт “саарал жагсаалт”-аас гарсан боловч ФАТФ-ын Зөвлөмж 15-ыг хэрэгжүүлж, виртуал хөрөнгөтэй холбоотой харилцааг зохицуулсан үндэсний хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх үүрэг хүлээсэн хэвээр байна.

ФАТФ-ын 2021 оны 7 дугаар сард нийтэлсэн “ФАТФ-ын виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн шинэчилсэн зөвлөмжийн 2 дахь 12 сарын дүгнэлт” баримт бичигт хийсэн судалгаанаас үзэхэд судалгаанд хамрагдсан нийт 128 орноос 58 нь холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлсэн байсан. Хууль батлагдсанаар манай улс тус 58 орны нэг болсон бөгөөд ингэснээр

дэлхийн зах зээлийн хурдацтай хөгжил дэвшилтэй хөл нийцүүлэн алхах боломжийг бидэнд олгож байна.

Үүний дагуу улс орнууд хориглох, анхааруулга гаргах, үнэт цаасны салбарын хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах болон тусгайлсан хууль гаргах замаар харилцан адилгүй зохицуулалтын арга хэмжээг авсан. Монгол Улс виртуал хөрөнгийг үнэт цаасны шинжийг хангахгүй гэж үзэж байгаа тул Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай тусгайлсан хуулийг боловсруулж Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталж, 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.


Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч болох арилжааны платформын үйлчилгээ үзүүлэгчдийг бүртгэх, үйл ажиллагаанд хяналт тавих, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тодорхойлох болон үүнтэй холбоотой эрх үүргийг тодорхойлсон харилцааг зохицуулахаар хуульчлагдсан.

Виртуал хөрөнгийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 4 сарын хугацаанд аливаа компанийг Санхүүгийн зохицуулах хорооноос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэхгүй бөгөөд бүртгэл 2022 оны 6 дугаар сарын 25-ны өдөр эхлэх юм. Дээрх өдрөөс хойш 3 сарын дотор виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид нь хуульд заасан шаардлагыг хангаж, Санхүүгийн

зохицуулах хороонд 2022 оны 9 дүгээр сарын 25-ны өдрөөс өмнө бүртгүүлнэ.

Тус хууль батлагдсанаар Санхүүгийн зохицуулах хорооноос нарийвчилсан харилцааг журмаар зохицуулах эрх олгогдсон тул дараах журмуудыг баталж мөрдүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна. Үүнд:

- “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам”;
- “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”;
- “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг тогтоох журам”;
- “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тогтоох журам”;
- “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”;
- “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох, түр зогсоох, бүртгэлээс хасах журам”;
- “Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэх журам”;
- “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”.



Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх хүсэлт гаргагч виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч этгээд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам”-д заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний шаардлага, бүтэц зохион байгуулалт, хүний нөөцийн шаардлага, программ хангамж, мэдээллийн технологид тавигдах шаардлага болон бүрдүүлэх 22 төрлийн баримт бичиг;

“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан шаардлага;

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан баримт бичиг зэрэг багтана.

Ийнхүү бүртгэж эхэлснээр хууль тогтоомжийн дагуу виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой бөгөөд койн, токен гаргагчид Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн шаардлагад нийцүүлэн олон нийтээс хөрөнгө татах, арилжааны жагсаалтад орох боломжтой юм. Нөгөөтээгүүр, холбогдох хууль, журмыг зөрчсөн этгээдэд оногдуулах хариуцлагыг Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн тухай хуульд зааснаар тус тус тодорхойлсон нь улс орны хэмжээнд бүрэн зохицуулалтад хамруулсан төдийгүй олон улсын байгууллагын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж буй явдал юм.

## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА



Үнэт цаасны зах зээлийн бодлогын зөвлөлийн анхдугаар хурал энэ сарын 20-ны өдөр боллоо. Хурлаар Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам, Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журмын нэмэлт өөрчлөлтийн төслүүдтэй танилцаад нийт гишүүдийн зүгээс дээрх төслүүдийг зарчмын хувьд дэмжсэн бөгөөд цаашид авч хэрэгжүүлэх арга, хэмжээний талаар ярилцаж, санал солилцлоо.

Мөн ирэх есдүгээр сард болох дараагийн хурлаар банкны реформ болон хөрөнгө оруулагчдад татварын таатай нөхцөл бүрдүүлэх чиглэлээр хэлэлцэхээр шийдвэрлэсэн юм.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2022 оны 02

дугаар сарын 28-ны өдрийн 86 дугаар тушаалаар шинэчлэн байгуулагдсан Үнэт цаасны зах зээлийн бодлогын зөвлөлийн даргаар Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, гишүүдээр Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Х.Алтай, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Лхагва, “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал О.Эрдэнэгэрэл, “Улаанбаатар үнэт цаасны бирж” ХК-ийн гүйцэтгэх захирал Ж.Золзаяа нарын нийт 12 байгууллагын удирдлага сонгогдон ажиллаж байгаа бөгөөд үнэт цаасны зах зээлд баримтлах ойрын болон дунд хугацааны бодлогыг тодорхойлоход оролцох, судалгаа хийх чиглэлээр иргэд, олон нийт, төрийн бус байгууллага, зохицуулалттай этгээдийн төлөөллөөс санал авах, хэлэлцүүлэг хийх, дүгнэлт зөвлөмж гаргаж Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх чиг үүрэгтэй юм.

### БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГҮҮЛЭХЭЭР ШИЛЖҮҮЛЛЭЭ

Улсын Их Хурал /УИХ/-ын чуулганы өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцлээ.

Энэ оны нэгдүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан нийт 529 банк бус санхүүгийн



байгууллага /ББСБ/ үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр байгууллагын нийт хөрөнгийн хэмжээ 3.0 их наяд төгрөгт хүрлээ. Түүнчлэн ББСБ-уудын зээлийн үйлчилгээний хүртээмж ч сайжирсан бөгөөд салбарын зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 2.4 дахин нэмэгдэж 1.4 саяд хүрсэн бол нийт харилцагчдын тоо давхардсан тоогоор 4.6 сая байна. Энэхүү өсөлт нь зээлийн нийлүүлэлтээс гадна технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд нэвтэрч эхэлсэнтэй холбоотой юм. Нөгөөтээгүүр банк бус санхүүгийн салбарт технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ буюу финтек өргөнөөр нэвтэрч байна. Тухайлбал, 32 ББСБ финтек зээлийн бүтээгдэхүүн гаргаж харилцагч, үйлчлүүлэгчдэдээ хүргээд байна. Гэхдээ технологид суурилсан санхүүгийн шинэ үйлчилгээ бий болж харилцагч, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн ч эрх ашгийг нь хамгаалсан, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар иргэдэд хүрэх санхүүгийн хүртээмжийг ахиулах боломжийг бүрдүүлсэн хууль, эрх зүйн орчин учир дутагдалтай байна. Ялангуяа төрөөс үзүүлж буй тусгай зөвшөөрлийн тоог бууруулах, хөгжлийн чиг хандлагыг олон улсын жишигт нийцүүлэх шаардлага тулгарч буй. Иймд Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн салбарт зохистой орчин бүрдүүлэх, санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх замаар санхүүгийн зуучлалыг хөгжүүлэх, салбарын хөгжлийг олон улсын жишигт хүргэх цаашилбал хяналтын оновчтой тогтолцоог бүрдүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхээр Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар ББСБ-ууд нь олон талт санхүүгийн үйлчилгээг эрхлэх боломж

бүрдэхийн сацуу салбарын оролцогчдыг чадавхижуулж, төрөлжсөн институт болгох, финтект суурилсан санхүүгийн үйлчилгээ болон компанийн засаглалын ил тод байдал, мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалт бий болно. Мөн Санхүүгийн зохицуулах хороо буюу зохицуулагч байгууллагын эрх үүргийг тодорхой болгож, нэгдсэн хяналт шалгалт хийх эрх зүйн орчин бүрдэхийн хамт мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх тогтолцоо сайжрах юм.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль нь 2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан бөгөөд өнгөрсөн хугацаанд нийт 9 удаа холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулж байсан. Харин өнөөдөр буюу 20 жилийн дараа ийнхүү шинэчлэх ажлыг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн дэмжээд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлээ.

### **ФИТЧ АГЕНТЛАГ МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙГ “ТОГТВОРТОЙ” ХЭВЭЭР ҮЛДЭЭЛЭЭ**

"Фитч агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг "В ангилалд буюу Тогтвортой" хэвээр үлдээснээ өчигдөр /2022.05.18/ мэдэгдлээ. Тус агентлаг дараах үндэслэлүүдээр Монгол Улсын эдийн засгийг тогтвортой байна гэж үнэлсэн байна.

**Бүтцийн давуу тал, гадаад байдал:** "В" түвшний бусад орнуудтай харьцуулахад Монгол Улсын засаглалын үзүүлэлтүүд сайн, нэг хүнд ногдох орлого нь өндөр, дунд хугацаанд эдийн засгийн өсөлт таатай төлөвтэй байна.

**Тогтвортой өсөлт ойрын хугацаанд хадгалагдана:** Монгол Улсын эдийн засгийн өсөлт өнгөрсөн онд 1.4 хувьтай байсан бол энэ онд 1.2 хувьтай байна. БНХАУ-ын хил дээрх худалдааны тасалдал удаан үргэлжлэх нь эдийн засгийн өсөлтийг бууруулах эрсдэлтэй ч 2023 онд хил дээрх худалдааны тасалдал багасна гэж тооцоолсон байна.

**Дунд хугацааны өсөлтийн таатай төлөв:** Монгол Улсын ДНБ-ий өсөлтийг 2023 онд 6.3, 2024 онд 6.8 хувьд хүрнэ гэж таамаглаж байна. Оюутолгойн далд уурхайг ашиглалтад оруулах, хилийн дэд бүтцийн холболтуудыг сайжруулах нь Монгол Улс байгалийн баялгийн нөөцөө бүрэн ашиглах боломжийг бүрдүүлнэ.

**Оюутолгойн бүтээн байгуулалтад гарсан ахиц:** Монгол Улсын Засгийн газар, гадаадын хөрөнгө оруулагч талуудын хооронд байгуулсан Оюутолгойн төслийн гэрээ нь Монгол Улсын экспортын орлого, төсвийн данс, гадаадын хөрөнгө оруулагчдад, цаашлаад далд уурхайн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэхэд эерэгээр нөлөөлнө гэж үзэж байна.



**Төсвийн алдагдал:** Монгол Улсын төсвийн алдагдал энэ онд ДНБ-ийн 4.4 хувьд хүрэх бол 2023 онд 3.7 хувь болж буурна гэж таамаглаж байна. “В” түвшний бусад орнуудын төсвийн алдагдал энэ онд 4.4 хувьтай байна.

**Засгийн газрын өр:** Засгийн газрын өр энэ оны эцэс гэхэд 4.3 нэгжээр нэмэгдэж ДНБ-ий 65.3 хувьд хүрнэ гэж таамаглаж байна. Дунд хугацааны өсөлтийн таатай төлөв, цар тахлаас өмнө төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байсан зэргээс Засгийн газрын өрийн динамик буурна гэж үзэж байна.

**Гадаад валютын нөөц:** Энэ оны эцэс гэхэд гадаад валютын нөөц 3.6 тэрбум ам. доллар байна гэж таамагласан. Монгол Улсын Хөгжлийн банк (МХБ)-ны өрийг тооцохгүйгээр 1.1 тэрбум ам.долларын гадаад өрийн хугацаа 2023–2024 онд дуусах тул гадаад валютын нөөц бага хэвээр байна.

**Инфляц:** Энэ онд инфляц 14.2, 2023 онд 10.8 хувь болж буурах төлөвтэй байна.

**Байгаль, орчин, нийгмийн удирдлага:** Монгол Улс улс төрийн тогтвортой байдал, хүний эрх чиглэлээр “5[+]”, хууль дээдлэх ёс, институтийн болон зохицуулалтын чанар, авлигын хяналт чиглэлээр “5” үнэлгээ авсан байна.

## ДААТГАЛЫН БАГЦ ХУУЛИЙН ТӨСӨЛД САНАЛ АВЧ ЭХЭЛЛЭЭ

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа–2050”, “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021–2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны

бодлогын баримт бичиг, 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Даатгалын салбарын эрх зүйн шинэчлэлтийг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилтыг тусгасан.

Энэ зорилтын хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яамнаас Даатгалын багц хуулийн төсөл болох Даатгалын тухай, Даатгалын зуучлалын тухай, Жолоочийн даатгалын тухай хуулийн төслүүдийг тус тус боловсруулан Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу салбарын оролцогчид болон олон нийтээс санал авч эхэллээ.

## ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САНГИЙН СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧТЭЙ УУЛЗЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан өнөөдөр Олон улсын валютын сан /ОУВС/-гийн суурин төлөөлөгч Юн Сок Хёнг хүлээн авч уулзлаа.



Уулзалтын эхэнд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Санхүүгийн зохицуулах хорооноос авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ, санхүүгийн салбарын өнөөгийн төлөв байдлын талаар мэдээлэл өглөө. Тэрээр цар тахлын нөлөөллөөс шалтгаалж өнгөрсөн 2 жил эдийн засгийн идэвхжил суларч санхүүгийн салбар томоохон сорилтуудтай тулгарсан ч Санхүүгийн зохицуулах хороо санхүүгийн салбар тэр дундаа хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлд бодлого, зохицуулалтын олон арга хэмжээг хэрэгжүүлж чадсан. Үүний үр дүнд салбарын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 24 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 8,7 пунктээр өссөн. Мөн хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 97,5 хувиар өсөж, 6 их наяд төгрөг болж түүхэн дэх хамгийн өндөр үзүүлэлтийг үзүүлсэн гэдгийг онцлоод зохицуулалтын салбар

шинээр нэмэгдэж байгаа мөн төрийн өмчит компаниудыг олон нийтийн болгох бэлтгэл ажлыг хангах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, ил тод хяналтын тогтолцоог бүрдүүлэх зэрэг нэлээдгүй ажлыг хэрэгжүүлэх хүрээнд хамтарч ажиллах талаар санал солилцсон юм.

Ялангуяа виртуал хөрөнгийн бүртгэл, зөвшөөрөл, банк бус санхүүгийн салбарт финтек зохицуулалтын орчинг бүрдүүлэх цаашилбал системийн эрсдэл, тогтвортой бөгөөд хүртээмжтэй байдлыг хангах чиглэлд хэрхэн хамтарч ажиллах талаар санал солилцлоо.



ОУВС-гийн суурин төлөөлөгч Юн Сок Хёнг санхүүгийн салбарыг хөгжүүлэх чиглэлд зохицуулагч байгууллагын хувьд бодлогын арга хэмжээнүүдийг шуурхай авч, үр дүнтэй хэрэгжүүлж байгааг онцлоод цаашид хамтран ажиллахад бэлэн гэдгээ илэрхийллээ.

## “ДААТГАЛЫН САЛБАР ДАХЬ ЦАХИМ ШИЛЖИЛТ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛО

Бизнесийн бүхий л салбарт цахим шилжилт хурдацтай явагдаж байгаа өнөө үед санхүүгийн салбар, тэр дундаа санхүүгийн хэрэглэгчдийн өдөр тутмын амьдралтай уялдаа бүхий даатгалын үйл ажиллагаа нь үе шаттайгаар цахимжиж байна. Даатгалын бүтээгдэхүүний загварыг боловсруулах, үнэ тогтоох, маркетинг борлуулалт, гэрээ байгуулах, нөхөн төлбөр олгохоос эхлээд даатгуулагчаа халамжлах үйл ажиллагаа гээд бүхий л шат дамжлаганд технологийн дэвшлийг хэрэгжүүлэх хандлага бий болоод байна. Ялангуяа “Ковид-19” цар тахлын улмаас олон улсын хэмжээнд хөл хорио, хилийн хоригтой холбоотойгоор ихэнх бизнесийн үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжихийн сацуу технологийн дэвшлийг ашиглах шаардлага, сонирхол нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо Монголын даатгалын холбоо, Монголын даатгалын



зуучлагчдын холбоо, Албан журмын даатгалын холбоо болон даатгалын компанийн удирдлагуудыг хамруулсан “Даатгалын салбар дахь цахим шилжилт” хэлэлцүүлэг зохион байгууллаа. Энэ үеэр цахим шилжилт хийх шаардлага, түүний зохицуулалтын талаар Санхүүгийн зохицуулах хорооноос мэдээлэл хийсэн бол Монголын даатгалын холбоо даатгалын салбарт хэрэгжүүлж буй цахим үйл ажиллагааны талаар танилцууллаа. Мөн “Бодь даатгал” ХК, “Тэнгэр даатгал” ХХК даатгалын андеррайтинг, бүтээгдэхүүн борлуулалт, нөхөн төлбөр олголт болон бусад үйл ажиллагаанд нэвтрүүлж буй цахим шилжилт, Монголын даатгалын зуучлагчдын холбооноос даатгалын борлуулалтын сувгийг өргөжүүлэхэд цахим үйл ажиллагааны үүрэг, “Финс брокерс” ХХК давхар даатгал, хамтын даатгалын үйл ажиллагааны талаар тус тус мэдээлэл өгч, танилцуулсан юм.

Сонирхуулахад, “Deloitte”-аас гаргадаг даатгалын салбарын хэтийн төлөвийн тайланд энэ онд нийт даатгалын компанийн 74 хувь нь хиймэл оюун ухаанд суурилсан, 72 хувь нь үүлэн технологид, 67 хувь нь дата аналитик, 63 хувь нь аппликэйшнд чиглэсэн үйл ажиллагаанд төсвөө нэмэгдүүлэх төлөвтэй байгааг онцолжээ. Мөн хиймэл оюун ухаанд суурилсан үйл ажиллагааг нэвтрүүлснээр зардал 30 хүртэл хувь буурч, борлуулалт 20–130 хувиар нэмэгдсэн талаар дурдсан байна. Түүнчлэн ажлын бус цагаар чатботоор дамжин даатгуулагчид хүргэсэн бүтээгдэхүүн нь нийт борлуулалтын 10 орчим хувийг эзлэх ба энэ нь даатгуулагчтай биечлэн харилцах цагийг 40 хувиар бууруулжээ /Эх сурвалж: *Kearney analysis*/. Даатгалын салбарын цахимжилтын зэрэгцээ инсуртек компаниудын хөгжил огцом өсөлтийг үзүүлж, энэ чиглэлийн компаниуд өнгөрсөн оны эхний 9 сарын байдлаар олон улсын хэмжээнд 10.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг татсан байна /Эх сурвалж: *Reuters*/. Үндсэндээ инсуртекийн сүүлийн жилийн өсөлт нь цар тахлын өмнөх 3–4 жилийн өсөлтийг нийлүүлсэнтэй тэнцэхүйц хэмжээтэй байгааг McKinsey Global Survey-д дурджээ.

## БАЙР СУУРЬ

### ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД МЭРГЭЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХИЙН АЧ ХОЛБОГДОЛ

*Энэ удаагийн ярилцлагаар институциональ буюу мэргэжлийн хөрөнгө оруулагчдын талаар Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын ахлах референт Н.Энхбаатартай ярилцлаа.*



*Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль 2013 онд батлагдаж, 2014 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Дээрх хууль батлагдсантай холбоотойгоор сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалтын сангууд /ХОС/ тэр дундаа хамтын сангууд шинээр бий болж эхэлж байна. Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурийг нэмэгдүүлэх хүрээнд ямар бодлого, зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна вэ?*

Улсын Их Хурлаас 2013 онд баталсан Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар ХОС-ийн төрөл, хэлбэр, санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хүрээнд хөрөнгө оруулалтын менежментийн компани /ХОМК/-д тусгай зөвшөөрөл олгох, сангийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, хөрөнгийг хадгалах, хяналт тавих болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зэрэг харилцааг зохицуулсан. Уг хууль батлагдсанаар хөрөнгө оруулалтын хуримтлал үүсэх, дотоодын иргэн, аж ахуйн нэгж өөрсдийн хөрөнгийг мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч ХОС-уудаар дамжуулан удирдуулах эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос

хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хамтын болон хувийн ХОС-г үүсгэн байгуулах, үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулсан нэр бүхий 8 журмуудыг батлан мөрдүүлэн ажиллаж байна.

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 32 ХОМК хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа бол нийт 24 хувийн ХОС, 2 хамтын ХОС хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхэлж байна. Ийнхүү ХОС-ийн тоо өсөж байгаа нь мэргэжлийн хөрөнгө оруулалтын баг дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын сул чөлөөтэй байгаа мөнгөн хөрөнгө, хуримтлалыг тооцоо, судалгаа, зах зээлийн шинжилгээнд үндэслэн хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, дотоодын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, улмаар мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурь тогтолцоо бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн ХОС нь гадаадын хөрөнгө оруулалтын урсгалыг дотоодын зах зээл рүү татах чухал сувгуудын нэг болдог бөгөөд ХОС-ууд идэвхжиж байгаа энэ цаг үед жижиг хөрөнгө оруулагчид хамтын ХОС, ХОМК-иар дамжуулан мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйлчилгээ авч, хөрөнгө оруулалт хийснээр урт хугацаанд хөрөнгөө өсгөх, өгөөж хүртэх, ногдол ашиг авах боломж бүрддэг.

Санхүүгийн зохицуулах хорооноос ХОМК, ХОС-ийн зохицуулалтын журмуудыг баталснаас хойш өдгөө 8 гаруй жилийн хугацаа өнгөрч байгаа бөгөөд олон улсын санхүүгийн зах зээлд гарч буй өөрчлөлт, хамтын сангийн хөгжлийн шинэ хандлага, зах зээлийн нөхцөл байдал болон өөрийн орны онцлогт нийцүүлэн дээрх журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулж, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох шаардлага тулгарах болсон. Энэ ажлын хүрээнд Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагын хүрээнд ХОМК-ийн үйл ажиллагаа болон ХОС-г үүсгэн байгуулахтай холбоотой журмуудыг шинэчлэн батлах ажлыг хийж, улмаар 2022

оны 2 дугаар улиралд багтаан журмын төслүүдийг Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаанаар батлуулахаар ажиллаж байна. Тус журмын төслүүдэд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон журмын зохицуулалтын зөрүү, давхардлыг арилгаж, хамтын болон хувийн ХОС-ийн хэлбэрээс хамаарч бүрдүүлэх баримт бичиг, тавигдах нөхцөл, шаардлагыг ялгаатай байдлаар нарийвчлан тогтоож, хялбаршуулж, хамтын хаалттай, нээлттэй болон биржээр арилжаалагддаг сангийн төрөлд тавих зохицуулалтыг шинээр тусгаж, хамтын ХОС-ийн үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдал, засаглал, активт тавих шаардлагыг олон улсын нийтлэг жишигт нийцүүлсэн.

*Хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулагчдын сонирхол их байгаа боловч бүтээгдэхүүний төрөл, сонголт муу байгаа талаар олон жил ярьж ирсэн. Үнэт цаасны зах зээл дээр шинэ бүтээгдэхүүний тоо, хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажлуудын талаар дурдана уу?*

Өнгөрсөн хугацаанд дотоодын хөрөнгийн зах зээлд зөвхөн хувьцаа, бонд, Засгийн газрын үнэт цаас гэсэн 3 төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн л арилжаалагдаж ирсэн. Тэгвэл Санхүүгийн зохицуулах хорооноос гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын хөрөнгийн зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, шинэ бүтээгдэхүүний тоог өсгөх, үнэт цаасны арилжаа, хөрвөх чадварын түвшнийг бууруулахгүй байх зорилтын хүрээнд бодлого, зохицуулалтын цогц арга хэмжээг хэрэгжүүлж, үнэт цаас гаргагч, зах зээлд оролцогч, мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажилласан 2 жил /2020–2022/-ийн хугацаанд нийт 36 төрлийн санхүүгийн шинэ бүтээгдэхүүн гарч, улмаар 2021 онд зах зээлийн үнэлгээ 6.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 97.5 хувиар өссөн бол нийт үнэт цаасны арилжаа 1.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 21.6 дахин өссөн өндөр өсөлт, ололт амжилтыг харуулсан.

Хөрөнгийн зах зээлд чанартай, хөрвөх чадвартай бүтээгдэхүүний тоо өсөж байгаа нь хөрөнгө оруулалт хийх эрэлт, хэрэгцээ өндөр байгааг харуулж байгаагаас гадна мэргэжлийн хөрөнгө оруулагчид олноор бий болж, үйл ажиллагаа нь улам өргөжихөд чухал нөлөө үзүүлж байна. Санхүүгийн зохицуулах хорооноос мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурийг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж ирсний үр дүнд 2020 онд Үндэсний хувьчлалын сан анхны хамтын хаалттай ХОС бий болж байсан. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 147, 148 дугаар тогтоолоор “Мандал хуримтлал” хамтын нээлттэй ХОС болон “Хөрөнгө оруулагч үндэстэн” хамтын нээлттэй ХОС-г үүсгэн байгуулах баримт бичгийг тус тус баталсан бөгөөд ингэснээр хөрөнгийн зах зээлд анхны хамтын нээлттэй ХОС-ууд бий болох эхлэл тавигдаж байгаагаараа онцлог юм.

Олон улсын туршлагаас харахад мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг шийдвэр гаргахад нь шаардлагатай мэдээллээр бүрэн хангах нь маш чухал байдаг бөгөөд ингэснээр хөрөнгө оруулагчид учирч болзошгүй эрсдэл болон хөрөнгө оруулалтын үр ашгаа зөв тооцоолж, урт хугацаанд оновчтой хөрөнгө оруулалт хийх боломжтой болдог. Үүнтэй холбогдуулан гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх оролцоог сайжруулах, үнэт цаас гаргагчдыг дотоодын хөрөнгийн зах зээлээс шаардлагатай санхүүжилт татахад дэмжлэг үзүүлэх бодлогын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос 2021 онд “Үнэт цаасны бүртгэлийн журам”, “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам” – уудыг шинэчлэн баталсан. Үр дүнд нь нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагаа хялбар, шуурхай болж, үнэт цаас гаргахтай холбоотой зардал, өртөг, зарцуулах цаг багасаж, компанийн хувьцаа болон өрийн хэрэгслийн зохицуулалтын давхардал арилснаас гадна үнэт цаасанд хөрөнгө оруулах шийдвэр гаргахад шаардлагатай байдаг мэдээллийн ил тод байдал сайжирч, олон улсын жишигт нийцсэн болно.

*Цаашид мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг дэмжих хүрээнд хэрэгжүүлэх бодлого, зохицуулалтын талаар дурдана уу?*

Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурийг бэхжүүлж, тэдгээрийн идэвх оролцоог нэмэгдүүлж, ХОС-ийн хууль тогтоомжийг боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцсэн зохицуулалтын орчныг бүрдүүлэх бодлого чиглэлийн хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж, улмаар 2022 оны Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслөөр ХОС-ийн хуулийн этгээдийн хэлбэрийг өргөтгөж гэрээний буюу хуулийн этгээдийн эрхгүй хэлбэрээр хувийн ХОС-г үүсгэн байгуулах, биржээр арилжаалагддаг сан /ETF/-тай холбоотой зохицуулалтыг шинээр тусгаснаас гадна хамтын ХОС-ийн хөрөнгө оруулах хэрэгслийн нэр төрлийг нэмэгдүүлж, ХОС бусад сангийн нэгж эрх /fund of funds/-д хөрөнгө оруулалт хийх бололцоог бүрдүүлсэн.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд дээрх зохицуулалтын нэмэлт, өөрчлөлтүүд орсноор үр дүнд нь дотоодын хөрөнгийн зах зээлд ХОС-уудын тоо өсөж, идэвх оролцоо нь нэмэгдэн олон улсын санхүүгийн зах зээл дээрээс гадаадын хөрөнгө оруулалтыг татах, цаашлаад зах зээлийн эрэлт талыг бүрдүүлэгч мэргэжлийн хөрөнгө оруулагчдын бааз суурь бэхжиж, ХОС-с гадна бусад мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч банк, банк бус санхүүгийн байгууллага болон даатгалын компаниудын зах зээл дэх оролцоо нэмэгдэх боломжтой болох юм.

# ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА УНАДАГ ДУГУЙН ХЭРЭГЛЭЭ

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах референт Н.Нарантуяа

Өмнөх нь 1-р нүүрт




**Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулж, нүүрсхүчлийн хийг багасгах,** агаарын бохирдлыг бууруулах ногоон эдийн засгийг бий болгох энгийн мөртлөө хялбар арга нь иргэдийн дунд унадаг дугуйн хэрэглээг нэмэгдүүлж, автомашинаар зорчих давтамжийг бууруулах юм. “Никель ганба” ХХК-ийн хийсэн дугуйн судалгаанд өндөр хэрэглээтэй хотод нэг хүнд 1.4 ширхэг, бага хэрэглээтэй хотод 25–30 хүнд нэг дугуй ногддог байна. Харин Улаанбаатар хотод 20 хүнд нэг ширхэг дугуй ногдож буй нь дугуйн бага хэрэглээтэйг илтгэнэ.



**Яагаад унадаг дугуйн хэрэглээ төдийлөн сайн нэмэгдэхгүй байна вэ?** Иргэд яагаад инфляц өсөж, автомашины өндөр гаалийн татвартай байхад автомашин худалдан авах нь нэмэгдэж байна вэ?

Гол асуудал нь унадаг дугуй унах таатай орчин буюу дэд бүтэц, иргэдийг сэдэлжүүлэх, унадаг дугуйны хөдөлгөөнийг зохицуулах зохицуулалт бүрдээгүй юм. Унадаг дугуй унахад тасралтгүй дугуйн замаар явах боломж байгаа эсэх, ажил, худалдааны төв, банк зэрэг үйлчилгээний байгууллагуудад хандахад дугуйны найдвартай зогсоол хангагдсан эсэх, дугуйтай явж байгаад осол гаргасан үед тээврийн хэрэгслийн жолооч, унадаг дугуйчин болон явган зорчигч хоорондын харилцааг зохицуулсан эрх зүйн орчин бүрдсэн эсэх, хэн зохицуулах зэрэг шийдвэрлэх асуудлууд бидэнд бий.

Нэг үгээр хэлбэл макро түвшний системтэй дэд бүтэц, хууль, эрх зүйн болон бодлогын шийдэл хэрэгтэй. Одоогийн байдлаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд унадаг дугуйг тээврийн хэрэгсэл гэж тодорхойлсон ба Зам тээврийн хөгжлийн яамнаас унадаг дугуйн хэрэглээг хангах бодлогын арга хэмжээ авахаар судалгааны түвшинд тодорхой ажлууд хийгдэж байна.



### Дугуйн замын сүлжээ

Одоогийн байдлаар 30 км дугуйн зам тавигдсан байгаа ч хоорондоо холбогдоогүй ба цаашид 162.8 км дугуйн зам барьж дугуйн замын сүлжээ үүсгэх шаардлагатай юм.



### Дугуйн зогсоол

Шаардлагатай дугуйн зогсоолын тоо хангалтгүйн улмаас иргэд холбогдох эрсдэлээс сэргийлэх, аюулгүй байдал хангагдсан дугуйн зогсоолын тоог нэмэгдүүлэх шаардлагатай. Дугуйн зогсоол бүрийн дэргэд засварын төв байршуулах. Дефактод дурдсанаар Улаанбаатарт дугуйг тээврийн хэрэгслээр ашиглахгүй байгаа гол шалтгаануудын нэг нь хяналтын системтэй, чанартай дугуйн зогсоолууд байхгүйгээс үүдэн гарч буй дугуйн хулгай юм. Автобусны буудал, сургууль, худалдаа, үйлчилгээний газрууд гэх мэт хүний хөл ихтэй, гэрэлтүүлэг сайтай газруудаар камерын хяналттай дугуйн зогсоолуудыг олноор бий болгож өгснөөр дугуйгаа алдахаас айх зүйлгүй болж, дугуй унагчдын тоог нэмэгдүүлж болно. Эдгээр зогсоолуудыг дугуй хийлэх тоног төхөөрөмж, энгийн засвар хийхэд шаардлагатай багаж хэрэгслээр тоногложноор дугуй унах илүү таатай нөхцөлийг бүрдүүлж өгнө.



### Бодлого, эрх зүйн орчин

Түүнчлэн Засгийн газраас унадаг дугуйн хэрэглээг нэмэгдүүлэх бодлогоор хангах, олон нийтийг ухамсрыг нэмэгдүүлэх нь ихээхэн чухал юм.

## ФИНТЕК БА РЕГТЕК

### 2022 ОНЫ ФИНТЕКИЙН 10 ТРЕНД

Ковид-19 цар тахал гарснаар олон салбарт хямрал нүүрлэсэн бөгөөд энэ нь финтекийн салбарт ч мөн адил нөлөөлсөн юм. Хөл хорионы улмаас банк, хадгаламж зээлийн хоршоо, даатгалын компаниуд зарим салбараа хаахад хүрсэн. Гэвч эдгээр саад бэрхшээлээс үл хамааран санхүүгийн салбарт санхүүгийн программ хангамж, дижитал үйлчилгээ хөгжих орон зай илүү нэмэгдэж, хөгжил хурдацтай явагдахад цар тахлын үеийн нөхцөл байдал ихээхэн түлхэц болсон. Цар тахал гарснаас хойш АНУ-ын хүн амын 42.0 хувь дор хаяж нэг финтек платформ ашиглаж, хүмүүсийн ямар нэгэн санхүүгийн аппликейшн, программ татаж авах нь 26.0 хувиар нэмэгдсэн байна.

#### 2021–2022 ОНЫ ФИНТЕКИЙН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭ

Ирланд улсад төвтэй IT үйлчилгээ, консалтингийн Accenture компанийн цар тахлын үеийн финтекийн салбарт хийсэн дүн шинжилгээгээр дижитал платформд хөрөнгө оруулалт хийсэн компаниуд ирээдүйд зах зээлд тэргүүлэгч болох магадлал өндөр хэмээн таамаглаж байна.

- Venture Scanner судалгааны байгууллагын мэдээлснээр 2021 онд финтект оруулсан нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 2020 онтой харьцуулахад 144.0 хувиар өссөн байна.
- BCG консалтинг компанийн мэдээлснээр 2020 онд шинээр байгуулагдсан стартап компанийн тоо 2019 онтой харьцуулахад 3 дахин нэмэгдсэн байна.



Дээрх тоон мэдээллээс харахад дэлхийн финтекийн зах зээл 2026 он гэхэд 31.5 тэрбум ам.долларт хүрнэ гэж олон улсын зах

зээлийн судалгааны байгууллагууд таамаглаж байна. Энэ нь 2016 оны үнэлгээтэй харьцуулахад 11.0 дахин өссөн үзүүлэлт болох юм.

Финтекийн салбарын хөгжил нь санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний суурь технологиос хамаардаг. McKinsey, Accenture, Deloitte зэрэг технологийн тэргүүлэх компаниуд дараах 10 зүйлийг 2022 онд финтекийн тренд болно хэмээн тооцоолж байна.

#### 1. Нээлттэй АПИ (аппликейшн программчлалын интерфэйс)

АПИ буюу хэрэглээний программчлалын интерфэйс нь хоёр программ хоорондоо харилцах боломжийг олгодог программ хангамжийн блок юм. Өөрөөр хэлбэл АПИ нь программ хангамжийг хэрхэн яаж нэгтгэх, хэрхэн хамтран ажиллахыг тодорхойлдог. Санхүүгийн салбарт АПИ нь үйлчлүүлэгчийн зөвшөөрөлтэйгөөр түүний мэдээллийг гуравдагч талд дамжуулах зарчмаар ажилладаг. Мэдээлэл солилцооны энэхүү загвар нь банкны үйлчлүүлэгчдэд ашигтай. Тодруулбал, нэгэн банкны байнгын үйлчлүүлэгч банкаа солихыг хүсдэггүй, харин тухайн банк дижитал үйлчилгээ нэвтрүүлж эхлээгүй байна гэж бодъё. Үйлчлүүлэгч өөрийн зарлага, орлого, зарцуулалтаа хянах зорилгоор санхүүгийн мэдээлэл, задаргаагаа харахыг хүснэ. Нөгөө талаас, банк үйлчлүүлэгчээ алдахыг хүсэхгүй. Энэ тохиолдолд АПИ-ийн тусламжтайгаар дүн шинжилгээ хийх гуравдагч этгээдэд үйлчлүүлэгчийн мэдээллийг дамжуулж, ингэснээр үйлчлүүлэгч дансны үлдэгдэл, зарцуулалтаа хянах, онлайн худалдаа хийх, зээл авах зэрэг олон төрлийн үйлчилгээг хялбар, хурдан шуурхай авах боломжтой болдог.

Судалгааны Статиста байгууллагын судалгаагаар 2024 он гэхэд 63.8 сая хүн АПИ ашигладаг болно гэж таамаглаж байгаа нь 2020 онтой харьцуулахад 5.0 дахин их тоо юм.

#### 2. Зүйлсийн интернэт (IoT)

Зүүдэг мэдрэгч төхөөрөмж нь финтекийн салбарт олон давуу талтай байдаг. Тухайлбал:

- Санхүүгийн байгууллагууд нь мобайл банкны аппликейшны тусламжтайгаар үйлчлүүлэгчдийн зан төлөвийг тандах;

- Уламжлалт ПОС машины оронд хөдөлгөөнт ПОС машин ашиглах;
- Банкны сүлжээний төхөөрөмжийн хамгаалалт IoT дээр суурилдаг бөгөөд систем нь төхөөрөмжүүдийг хянах, удирдах, ашиглагдаагүй төхөөрөмжийг идэвхгүй болгох үүрэг гүйцэтгэдэг;
- Энгийн кредит картын оронд ухаалаг утас, ухаалаг цаг, бугуйвчаар төлбөр тооцоо хийх;
- Ухаалаг хөргөгчтэй чанга яригчаар ярин хүнс захиалах, төлбөрөө төлөх;
- Ухаалаг утас, бугуйвчийг биометрийн баталгаажуулалтад ашиглах.

Хэрэглэгчдэд хүрч буй үйлчилгээг илүү хялбар болгох, хэрэглэгчдийн хүсэл, сонирхлыг ойлгох үүднээс финтекийн компаниудын дээрх төхөөрөмжүүдийг зах зээлд нэвтрүүлэх нь нэмэгдсээр байна.

2021 онд IoT-ийн зах зээл 48.9 тэрбум ам.доллар байсан бол 2028 онд 118.2 тэрбум ам.доллар болж өсөх магадлалтай байна.

### 3. Рэгтек

Санхүүгийн байгууллагууд нь холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, нягтлан бодох бүртгэл, татвар, орлогын тайлан хөтөлж, хуваарийн дагуу холбогдох бичиг баримтыг зохицуулалтын байгууллагад хүргүүлдэг. Зохицуулалтын байгууллага нь тухайн байгууллага хууль журмын дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа эсэх, ирүүлсэн тайлан мэдээний үнэн зөв эсэхийг хянан баталгаажуулдаг. Харин аливаа байгууллага олон улсын зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд тэдний үйл ажиллагааны чиглэл болон холбогдох дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавихад төвөгтэй болдог. Ийм учраас дүрэм, журмаас гажууд асуудлыг олж тодорхойлох, тэдгээрийг дүрэм, журамд нийцүүлэх, олон давтагддаг ажлыг автоматжуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад рэгтек хэрэгтэй болдог.

Grand View судалгаагаар рэгтекийн зах зээл 2025 он гэхэд 25 хувиар өснө гэж тооцож байна.

### 4. Биометрийн баталгаажуулалт

Кибер аюулгүй байдлын мэргэжилтнүүд биометрийн баталгаажуулалт буюу хүний хурууны хээ, царай, дуу хоолойг хуурамчаар хийх боломжгүй тул энгийн нууц үг, ПИН кодоос илүү найдвартай гэж үздэг. Санхүүгийн байгууллагын үйлчлүүлэгчдийн 93 хувь нь дансны хамгаалалт хамгийн чухал гэж үздэг учир

финтек биометрийн баталгаажуулалтын технологид тэргүүлэх салбар болж байна.

Статиста байгууллагын тооцооллоор дэлхийн биометрийн зах зээл 2020 онд 36.6 тэрбум ам.доллар байсан бол 2025 онд 68.6 тэрбум ам.долларт хүрнэ гэж үзсэн.

### 5. Хиймэл оюун ухаан

Санхүүгийн салбарт маш их хэмжээний өгөгдөл, мэдээлэл тогтмол үүсдэг бөгөөд эдгээр мэдээллийг хиймэл оюун ухааны тусламжтайгаар цуглуулж, ангилж, хадгалж болдог. Ухаалаг алгоритмууд нь банк, зээл, даатгалын компаниудын ажлыг хөнгөвчилж, үр дүнтэй болгодог. Тухайлбал:

- Банкны программ дахь хэрэглэгчийн зан төлөвийг судалдаг. Хэрвээ платформ руу гаднын хүн нэвтрэх, сэжигтэй үйлдэл ажиглагдвал хиймэл оюун ухаан нь банк болон хэрэглэгчдэд шууд мэдээлдэг.
- Хиймэл оюун ухаанд суурилсан виртуал туслах буюу чатботууд үүссээр байна.
- Хэрэглэгчийн дадал зуршилд дүн шинжилгээ хийдэг.
- Хиймэл оюун ухааны алгоритм нь бизнесийн үр дүнг урьдчилан таамаглахад тусалдаг.

Mordor Intelligence-ийн тооцооллоор 2026 он гэхэд хиймэл оюун ухааны зах зээл гурав дахин өсөхөөр байна.

### 6. Блокчэйн

Санхүүгийн салбарт даатгал, зээлийн байгууллагуудаас илүү банкнууд блокчэйнийг түлхүү ашиглаж байна. Блокчэйний тусламжтайгаар дараах зүйлсийг хийх боломжтой. Үүнд:

- Мөнгө хаанаас орж ирсэн, юунд зарцуулагдсан зэрэг мэдээллийг автоматаар бүртгэдэг.
- Гүйлгээ бүр тусдаа блокт бүртгэгддэг тул хэрэглэгчийн оруулсан мэдээллийг өөрчлөх, устгах, хуурамчаар үйлдэх боломжгүй. Энэ нь санхүүгийн гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэлийг багасгадаг.
- Олон улсын төлбөр тооцоо, шилжүүлгийг богино хугацаанд, шимтгэл багатайгаар хийх боломжтой.

### 7. Үүлэн технологид суурилсан систем

Үүлэн технологи нь үр ашиггүй зардлыг хязгаарлах, өгөгдлийг зүй зохистойгоор ашиглах боломжийг олгодог бөгөөд олон талаас зэрэг хандаж ажилласнаар орон зайны хувьд хэмнэлттэй байж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх боломжтойгоороо онцлог.

Үүлэн технологи нь банк, финтекийн салбарын дижиталчлалыг дэмжиж ажилладаг ба цаашид энэ зах зээлийн жилийн дундаж өсөлт 24.4 хувь хүрнэ гэж таамаглаж байна.

### 8. Виртуал карт

Виртуал карт нь түр хугацааны дижитал аналог бүхий 16 оронтой тоо бөгөөд интернэт орчинд төлбөр тооцоо хийхэд аюулгүйн баталгаа болж байна. Виртуал карт нь ухаалаг утсан дахь дижитал түрийвчид хадгалагддаг ба биет болон онлайн дэлгүүрүүдэд контактгүй төлбөр тооцоо хийхэд ашиглагддаг. Виртуал карт нь аливаа худалдан авалт хийгдэх бүрд тусгай дугаар үүсгэгддэг тул аюулгүй, найдвартай арга хэрэгслийн нэгд тооцогддог.

Forbes-ийн мэдээлснээр санхүүгийн байгууллагууд виртуал картыг ашигласнаар уламжлалт карт олголтын зардлыг хэмнэх, төлбөр төлөх хугацааг багасгах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зэрэг давуу талуудтай.

### 9. Робот процессын автоматжуулалт

Санхүүгийн программ хангамж хөгжүүлэгч компаниуд нь хүний үйлдлийг гүйцэтгэх роботыг бүтээснээр байнга давтагддаг дараах үйлдлүүдийг гүйцэтгэх боломжтой. Үүнд:

- Өгөгдөл оруулах
- Тайлан гаргах
- Санхүүгийн мэдээллийг удирдах
- Хэрэглэгчийн төлбөрийн чадварыг шалгах
- Даатгалын нөхөн төлбөрийг шийдэх
- Хэрэглэгчдээс ирсэн хүсэлт, гомдлыг шийдвэрлэх
- Хэрэглэгчдийг бүртгэх.

Juniper research-ийн судалгаагаар робот процессын автоматжуулалт нь финтекийн салбарын чухал хэсэг бөгөөд энэ салбарын орлого 2023 он гэхэд 400 хувиар өснө гэж таамаглаж байна.

### 10. Дуу хоолойгоор баталгаажсан төлбөр тооцоо

Хүмүүс ухаалаг төхөөрөмжтэй өөрийн дуу хоолойгоор харилцан мэдээлэл хайх, дуудлага хийх, сонсох дуугаа сонгох, бараа захиалах зэрэг олон үйлдлийг хийх болсон. Финтек компаниуд ч хүмүүсийн энэхүү хандлагыг ажиглан, санхүүгийн салбарт дижитал туслахын үйлчилгээг нэвтрүүлсээр байна. Жишээлбэл:

Дуу хоолойн биометр нь хэрэглэгчийн мэдээллийг найдвартай хамгаална.

Хэрэглэгч төлбөр тооцоог дуу хоолойгоор хийх, үлдэгдлээ шалгах зэрэг үйлдлийг хийх боломжтой. Гараар өгөгдөл оруулах шаардлагагүй.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд дуут технологийг ашигласнаар санхүүгийн хүртээмж нэмэгдэнэ.

Capgemini Digital Transformation Institute-ийн судалгаагаар хэрэглэгчдийн 44 хувь нь дуу хоолой таниулан санхүүгийн үйлчилгээ авах сонирхолтой байгааг тогтоожээ. Статиста-ийн судалгаагаар дуут туслах төхөөрөмжийн тоо 2025 он гэхэд дэлхийн хүн амаас их буюу 8.4 тэрбум төхөөрөмжид хүрч, 2026 он гэхэд дуу хоолой, яриагаар таних технологийн зах зээл гурав дахин өсөх хандлагатай байна.



## СУДЛААЧИЙН ИНДЭР

### ЗАН ТӨЛӨВИЙН ЭДИЙН ЗАСАГ БА САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТ

*Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.*

*Гүйцэтгэсэн:*

*Санхүүгийн зохицуулах хорооны зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын газрын референт, badamsuren@frc.mn*

#### ХУРААНГУЙ

Зан төлөвийн эдийн засгийг дэлхийн улс орнууд бодлого боловсруулах, дээд түвшний шийдвэр гаргахад түгээмэл ашиглах болжээ. Зан төлөвийн эдийн засаг нь санхүүгийн салбарт хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, санхүүгийн бусад зохицуулалтыг хийхэд ашиглагдаж байна. Энэхүү судалгаа нь зан төлөвийн эдийн засгийн талаар ойлголт өгөх, санхүүгийн зохицуулалтад хэрхэн ашиглагдаж болох талаар мэдээлэл өгөх зорилготой бөгөөд удиртгал, зан төлөвийн эдийн засгийн талаарх ойлголт, зан төлөвийн эдийн засгийг хэрэгжүүлж буй олон улсын туршлага, дүгнэлт гэсэн бүлгээс бүрдэнэ.

#### УДИРТГАЛ

Бид барааны, хүнсний дэлгүүр болон кофе шопд худалдан авалт хийхээр явж байхдаа “Үнэгүй” гэсэн бичигтэй сурталчилгаатай таарах нь элбэг. Тухайлбал, “Нэгийг авбал нэг үнэгүй” гэсэн самбар түгээмэл үзэгддэг бөгөөд энэ нь бизнес эрхлэгчид худалдан авагчдын сэтгэл зүйгээр дамжуулан орлогоо нэмэгдүүлэх нэгэн арга хэлбэр. “Нэгийг авбал нэг үнэгүй” гэсэн сурталчилгаа нь “2 бараа авахад тус бүр 50 хувийн хөнгөлөлттэй” гэсэн сурталчилгаатай үндсэндээ ижил боловч худалдан авагчид эхний сурталчилгаанд орсон “Үнэгүй” гэсэн үгэнд хариу үйлдэл үзүүлэх нь илүү түгээмэл байдаг байна. Энэ нь зан төлөвийн эдийн засгийг худалдааны маркетингт ашигладаг түгээмэл жишээ бөгөөд хэрэглэгчдийн шийдвэрт хэрхэн нөлөөлж болохыг ойлгох замаар маркетингийн стратегийг боловсруулдаг.

Зан төлөвийн эдийн засгийг маркетингийн салбарт ашиглаад зогсохгүй харилцаа холбоо, санхүү эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, төрийн удирдлага зэрэг маш олон салбарт ашиглах болжээ. Түүнчлэн, зан төлөвийн эдийн засаг нь ЭЗХАХБ – ийн зарим гишүүн орнуудын бодлогод нөлөө үзүүлэх болсон. Тэр дундаа, АНУ болон Их Британи улсууд зан төлөвийн эдийн засгийг бодлого боловсруулахдаа илүүтэйгээр ашиглах болов. Тухайлбал, АНУ Зээлийн картын хариуцлага болон ил тод байдлын тухай актыг 2009 онд хуульдаа тусгав. Хуульд тусгагдсан зээлийн карт нийлүүлэгчдийн хатуу зохицуулалт нь зарим талаар хэрэглэгчдийн зээлийн бодит өртгийг хэрхэн ухамсарлаж чадахгүй байгааг харуулах зан төлөвийн нотолгоонд суурилсан. Зохицуулалтын хүрээнд зарим төрлийн төлбөрийг хориглож, мөн компаниуд төлбөрийн талаарх ашигтай тооцоог гаргах үүргийг хүлээсэн. АНУ дахь бусад зан төлөвийг хамарсан санаачилгууд нь хэрэглэгчдэд хүргэх мэдээллийг хялбарчлах, стандартчилах зэрэг байна. Харин Их Британийн Засгийн газар Их Британийн бодлого боловсруулагчдад зөвлөх үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй Зан төлөвийн багийг бүрдүүлэн ажиллуулж байна. (OECD, 2014)

Зан төлөвийн эдийн засгийн хэрэглээ хурдацтай өсөн нэмэгдэхийн хэрээр хэрэглэгчдийн гаргасан зарим алдаанууд тогтмол бөгөөд урьдчилан таамаглах боломжтой болж байна. Зан төлөвийн эдийн засаг нь зохицуулагч байгууллагуудад зах зээлд илүү үр дүнтэй оролцох, зан төлөвийн эдийн засгийг ашиглан хэрэглэгчдийг зүй бусаар татаж буй бизнесүүдийг эсэргүүцэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах боломжийг олгодог.

## Хүснэгт. төлөвийн эдийн засгийг үйл ажиллагаандаа ашиглах нь

	АСУУЛТУУД
Үе шат 1: Хэрэглэгчдэд учирч болох эрсдэлийг тодорхойлж, эрэмбэлэх	1. Гажуудлаас үүдэлтэйгээр хэрэглэгчдэд хохирол учрах эрсдэлийг хэрхэн олж тодорхойлох вэ? 2. Тэдгээр эрсдэлийг хэрхэн эрэмбэлэх вэ?
Үе шат 2: Асуудлын үндсэн шалтгааныг ойлгох	<ul style="list-style-type: none"> <li>• Хэрэглэгчид сонголтоо оновчтой хийдэг үү?</li> <li>• Хэрэв хэрэглэгчид зан төлөвийн гажуудалтай бол, тэдэнд юу хэрэгтэй бас юу хүсдэг вэ?</li> <li>• Компанийг хамарсан асуудлуудад хэрхэн анализ хийх вэ?</li> <li>• Зах зээлийг хамарсан асуудлуудад хэрхэн анализ хийх вэ?</li> </ul>
Үе шат 3: Үр дүнтэй интервенцийг боловсруулах	<ul style="list-style-type: none"> <li>• Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад ямар интервенц хийх вэ?</li> <li>• Интервенц хийх шаардлагатай юу, тийм бол хэрхэн интервенц хийх вэ?</li> <li>• Интервенц хийснээр гарах үр нөлөөг хэрхэн үнэлэх вэ?</li> </ul>

### Үе шат 1: Асуудлыг тодорхойлж, эрэмбэлэх

#### Гажуудлаас үүдэлтэйгээр хэрэглэгчдэд хохирол учрах эрсдэлийг хэрхэн олж тодорхойлох вэ?

Гажуудлыг шууд ажиглах боломж нь маш ховор тохиолддог. Хүмүүсийн гаргадаг нийтлэг алдаануудад үндэслэн, хэрэглэгчдийн гаргасан алдаанаас үүдсэн хохирол хаана өндөр байгааг тодорхойлоход туслах багц шалгуур үзүүлэлтүүдийг санал болгож байна. Тэдгээр шалгуур үзүүлэлтүүд нь асуудалтай болон асуудал үүсгэж болзошгүй хэрэглэгч, компани болон бүтээгдэхүүний шинж чанарыг тодотгож харуулдаг. Асуудлыг илрүүлэх нэмэлт арга бол бүтээгдэхүүний эдийн засагт гүйцэтгэх анхдагч үүргийг тодорхойлж, дараа нь хэрэглэгчид уг бүтээгдэхүүнийг зорилгоо нь дагуу ашиглаж байгаа эсэх, эсхүл өөр зорилгоор ашиглаж байгаа эсэхийг үнэлэх юм.

#### Тэдгээр эрсдэлийг хэрхэн эрэмбэлэх вэ?

Асуудлын цар хүрээ нь эрэмбэлэхэд тэргүүлэх ач холбогдолтой байна.

### Үе шат 2: Асуудлын үндсэн шалтгааныг ойлгох

#### Хэрэглэгчид оновчтой сонголт хийж чадах уу? Хэрэв хэрэглэгчид гажуудалтай бол, тэд юу хүсэж, мөн тэдгээрт юу шаардлагатай байна вэ?

Асуудлуудад анализ хийхдээ бид учир шалтгааныг тайлбарлаж, дараагаар нотолгоог бүрдүүлэх шаардлагатай. Хэрэглэгчид алдаа гаргаж байгаа эсэх, хэрэв тийм бол ямар гажуудал асуудлын шалтгаан байж болохыг судлах шаардлагатай. Чухал нотолгоонуудад хэрэглэгчид өөр өөр нөхцөлд хэрхэн сонголт хийж байгаа байдал (жишээ нь хэрэглэгчид туршлага хуримтлуулахын хэрээр өөр сонголт хийдэг үү?), чухал бүтээгдэхүүний талаарх мэдээлэл болон хэрэгцээ зорилгоын талаар өөрсдийн мэдүүлэг зэрэг орно.

#### Компанийг хамарсан асуудлуудад хэрхэн анализ хийх вэ?

Компанийг хамарсан асуудлын хувьд зан төлөвийн талаарх ойлголт нь компанийн талаар ямар асуулт асуух мөн ямар мэдээлэл цуглуулах талаар мэдээлэл болж өгдөг. Чанарын

мэдээлэл хангалттай байж болох ч хэрэглэгчдийн зан төлөвийн талаарх тоон мэдээлэл шаардлагатай байж болно. Бүтээгдэхүүний онцлог шинж чанар болон практик байдал нь олон тооны компаниуд эсхүл зах зээлийн хувьд нийтлэг байдаг эсэхийг тодорхойлох нь чухал.

#### Зах зээлийг хамарсан асуудлуудад хэрхэн анализ хийх вэ?

Зах зээлийн хамарсан асуудлуудыг тодорхойлох нь илүү өндөр түвшний нотолгоо шаарддаг. Тэдгээр нь хэрэглэгчдийн талаарх судалгаа, лабораторийн туршилт эсхүл газар дээрх туршилтаар цуглуулсан мэдээллийг багтаана. Анализ нь компаниуд хоорондоо хэрхэн өрсөлддөг, бусад зах зээл болон зохицуулалтын ямар алдаанууд оршин байдаг, мөн хэрэглэгчдийн гажуудлууд тэдгээр хүчин зүйлстэй хэрхэн харилцан үйлчилдэг зэрэг өргөн хүрээг авч үзэх шаардлагатай.

### Үе шат 3: Үр дүнтэй интервенцийг боловсруулах нь

#### Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад ямар интервенц хийх вэ?

Английн санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах байгууллага нь зан төлөвийн асуудлыг шийдвэрлэх 4 арга замыг хэрэгжүүлдэг.

1. **Мэдээллээр хангах.** Тодорхой нэгэн арга хэлбэрээр мэдээллийг түгээх эсхүл зарим маркетингийг хориглохыг компаниудад шаардлага болгох;
2. **Сонголт хийх орчныг өөрчлөх.** Сонголтуудыг хэрэглэгчдэд хэрхэн хүргэх арга замуудыг өөрчлөх;
3. **Бүтээгдэхүүний борлуулалтыг хянах.** Бүтээгдэхүүнийг зөвхөн тодорхой сувгаар эсхүл тодорхой төрлийн хэрэглэгчдэд сурталчлах, борлуулахыг шаардлага болгох.

**Бүтээгдэхүүнийг хянах.** Мөлжлөгийн шинж чанартай бүтээгдэхүүн эсхүл бүтээгдэхүүний тухайн шинж чанарыг хориглох, бүтээгдэхүүнийг тусгай шинж чанартай байхыг шаардах.

#### Интервенц хийснээр гарах үр дүнг хэрхэн үнэлэх вэ?

Төрөл бүрийн арга хэмжээ авах, эсхүл интервенц хийхгүй байхын аль нэг сонголтыг хийхэд зардал болон ашгийг үнэлэх хэрэгтэй байдаг. Үүнд (i) зохицуулалтын арга хэмжээг

даван гарах, (ii) инновац бий болсноор гарах сөрөг ба эерэг нөлөө, (iii) өөр өөр хэрэглэгчдийн хооронд шилжүүлэг хийх (жишээ нь санхүүгийн нарийн мэдлэгтэй мэдлэггүй хэрэглэгчид), хэрэглэгчдийн сурах хүсэл эрмэлзэлд үзүүлэх нөлөө ба (v) тухайн асуудал зохицуулагч байгууллагад хамаарах эсхүл Засгийн газарт хамаарах эсэх зэрэг олон төрлийн хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай (FCA, 2013).

**АНУ-ын зээлийн картын хариуцлага болон ил тод байдлын тухай акт** 2009 оны 5 дугаар сард ерөнхийлөгч Обама Зээлийн картын хариуцлага болон ил тод байдлын тухай хуульд гарын үсэг зуржээ. Энэхүү хуулийг санхүүгийн хямралын үеэр хэрэглэгчдийн санхүүг хамгаалах зорилгоор баталжээ. Хуулийн зарим заалтууд нь АНУ-ын зээлийн картын компаниудын шударга бус, төөрөгдүүлсэн үйлдлийг эсэргүүцэх зорилготой байв. Баримт нотолгооноос харахад хувь хүний шийдвэр гаргалт нь цаг хугацааны хувьд хувьсан өөрчлөгддөг, яаралтай худалдан авалт хийхдээ ирээдүйд гарах томоохон зардлыг хэт багаар тооцох; зарим хэрэглэгчид зээлийн нөхцөл, шимтгэл эсхүл зээлийн хүүд гарах өөрчлөлт зэрэг ирээдүйд гарах зардалд хангалттай анхаарал хандуулдаггүй; шимтгэл хураамжийг үнэлэхдээ хэт өөдрөгөөр ханддаг байж болзошгүй.

## ДҮГНЭЛТ

Эдийн засгийн онолд хэрэглэгчдийг рационал шийдвэр гаргадаг гэж үздэг боловч бодит байдал дээр зан төлөвийн гажуудлаас үүдэлтэй сонголт хийдэг нь цаг хугацааны явцад батлагдсан. Зах зээлд үйл ажиллагаа явуулж буй ашгийн төлөө санхүүгийн байгууллагууд хэрэглэгчдийн зан төлөвийн гажуудлыг ашиглан ашгаа нэмэгдүүлэх, хэрэглэгчдийг өөрт татах стратегийг хэрэгжүүлж байдаг. Нөгөөтээгүүр, зан төлөвийн гажуудлыг ангилж, сайтар ойлгосноор санхүүгийн зарим зохицуулалтыг илүү үр дүнтэй болгож байдаг. Тухайлбал, хэрэглэгчид зээл авах, зээлийн карт ашиглахдаа банканд төлж буй шимтгэл, хураамжийг хэрхэн тооцоолдог талаар нарийн мэдлэггүй тул өөрийн мэдэлгүй төлөх ёстой хэмжээнээсээ их мөнгө төлж байдаг бөгөөд энэхүү асуудлыг АНУ-д Зээлийн картын хариуцлага болон ил тод байдлын тухай хуулиар зохицуулжээ. Тус хуульд зарим төрлийн шимтгэл хураамжийг авахыг хориглох, хэрэглэгчдийг илүү бодитой үнэн зөв мэдээллээр хангах зэрэг шаардлагуудыг тусгажээ. Энэхүү туршлагаас харахад Монгол улсад санхүүгийн хэрэглэгчдийн зан төлөвийн гажуудлыг судалж, ангилснаар хэрэглэгчдийн

Энэхүү хууль нь зарим төрлийн “халхлагдсан” шимтгэл хураамжийг хориглох, зээлдүүлэгчдийг хэрэглэгчдэд илүү хэрэгтэй, цаг тухайн мэдээллээр хангахыг шаардах зэрэг хэрэглэгчдийн зан төлөвийн гажуудлыг ашиглан зээлийн зах зээлд үзүүлж буй сөрөг нөлөөллийг хязгаарлах зорилготой. Хуулийн томоохон голлох заалтуудын нэг нь зээлдүүлэгч зээлийн хязгаараас давсан дүнгээр худалдан авалт хийсэн тохиолдолд шимтгэл хураамж ногдуулахаас илүүтэйгээр худалдан авалтыг цуцлах байв. Мөн төлбөрийг ямар үед хугацаа хэтэрсэн гэж тооцох, идэвхгүй байдлын төлбөрийг хэрхэн тооцох талаарх илүү тодорхой ойлголтыг өгөх торгуулийн шимтгэл хураамжийн тоо болон хэмжээг хязгаарлах зэрэг шинэ зохицуулалтыг нэвтрүүлсэн. Түүнчлэн, энэхүү хуульд дараах зохицуулалтыг оруулжээ: зээлдэгч зээлийн эргэн төлөлтийг хамгийн багаар хийх боломжтой хугацаа болон өртгийн тооцоолол, эргэн төлөгдөх дүн, мөн 36 сараас дээш хугацаанд эргэн төлөлт хийгдэх тохиолдолд ижил тооцоог гарган зээлдүүлэгч талаас мэдээлэх үүрэгтэй. Аргавал болон бусад судлаачдын 150 сая дансны мэдээлэлд үндэслэн хийсэн тооцооллоор “халхлагдсан” шимтгэл хураамжийг ил болгосноор жилд 21 сая ам.долларыг хэмнэсэн гэж гаргажээ.



эрх ашгийг хамгаалах боломжтой байна. Тухайлбал, даатгалын компаниудын борлуулж буй бүтээгдэхүүний үнийн задаргааг ил тод болгох, зээлийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудыг шимтгэл хураамжийг хэрхэн тооцож байгааг ил тод, дэлгэрэнгүй байдлаар мэдээлэхийг шаардах зэрэг зохицуулалтыг хийж болно. Зан төлөвийн эдийн засгийг санхүүгийн зохицуулалтад ашиглах нь зохицуулалтыг илүү үр дүнтэй болгох давуу талтай байна (OECD, 2017).

## ЭХ СУРВАЛЖ

1. Dambe, K., Hunt, S., Iscenko, Z., & Brambley, W. (2013). Applying behavioural economics at the Financial Conduct Authority. FCA Occasional Paper, (1).
2. DellaVigna, S. (2009). Psychology and Economics: Evidence from the Field. *Journal of Economic Literature*, 47, 315–372.
3. OECD. (2017). Behavioural insights and public policy: Lessons from around the world. OECD.



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

## Цуврал №12

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

# ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО ГЭЖ ЮУ ВЭ?

“Хадгаламж, зээлийн хоршоо гэдэг нь гишүүдийнхээ эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор гишүүддээ хадгаламж, зээлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлэх ардчилсан удирдлага, хамтын хяналт бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээдийг хэлнэ” гэж **Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд тодорхойлсон.**



ХЗХ

VS

Банк



Ашгийн төлөө бус		Бүтэц, зохион байгуулалт		Ашгийн төлөө
Гишүүдийн хэрэгцээ, шаардлагыг хангах		Анхдагч зорилго		Ашиг олох
Бүх гишүүд		Үйлчлүүлэгч		Шалгуур хангасан хүн бүр
Сайн дураар		Удирдлага		Цалин хөлсөөр ажиллуулдаг захирал
Бүх гишүүд /гишүүн бүр 1 саналын эрхтэй/		Шийдвэр гаргалт		Хувьцаа эзэмшигч 1 хувьцаа=1 санал
Зөвхөн гишүүдэд		Ашиг хуваарилалт		Зөвхөн хувьцаа эзэмшигчдэд
Бага шимтгэл хураамжтай		Хүү, шимтгэл		Ашгийн төлөө ажилладаг тул өндөр
Үйл ажиллагааны орлого		Хөрөнгийн эх үүсвэр		Орлогын урсгал + хувьцаа гаргах
Өмч хөрөнгө, зээлийн үйл ажиллагаанаас олсон ашигт ажиллагаанаас		Татвар		Өмч хөрөнгө, бүхий л орлого олох үйл ажиллагаанаас

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

## Цуврал №12

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

### ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО



Гишүүдийн эзэмшил бүхий санхүүгийн хоршооллын  
байгууллага

Market Business News. "Credit Union"



### Хадгаламж, зээлийн хоршооны гишүүний давуу тал:

- 01 Газар зүйн байршил, цаг хугацаанаас үл хамааран санхүүгийн үйлчилгээ хүртэх
- 02 Өндөр хадгаламжийн хүүгийн өгөөж хүртэх
- 03 Бага шимтгэл хураамж төлөх
- 04 Гишүүд хоорондын хамтын ажиллагаа нэмэгдэх
- 05 Зээлийн бага шаардлага

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

## САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

### САНХҮҮГИЙН ТООЦООЛОЛД СУРАЛЦЬЯ (ХИЧЭЭЛ №5–Н ҮРГЭЛЖЛЭЛ)



ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ  
ГАЗРЫН ДАРГА В.ЭНХБААТАР

#### МӨНГӨН УРСГАЛЫН ШИНЖИЛГЭЭ; ЦЭВЭР ӨНӨӨГИЙН ҮНЭ ЦЭНЭ, IRR, ЖИГНЭСЭН ӨГӨӨЖ

Мөнгөний “хэмжээ”, “хугацаа” –аар жигнэсэн өгөөж

Мөнгөний хэмжээнээс хамаарч “дискаунт хувь” өөр өөр байдаг. Тиймээс “дискаунт хувь”-ийг зарим тохиолдолд “мөнгөний хэмжээгээр жигнэсэн хувь” гэж нэрлэдэг. Тухайлбал, жилийн эхэнд ₮100.0 хадгалсан, хагас жилийн дараа ₮105.0 болсон, хагас жилийн дараа ₮105.0 дээр ₮50.0 нэмсэн бөгөөд жилийн эцэст нийт ₮170.0 болсон гэж төсөөлье. Өгөөжийн хувь хэд вэ?

Мөнгөний ирээдүйн ба өнөөгийн үнэ цэнийг тооцох талаар өмнөх хичээлд үзсэн бөгөөд богино хугацааны хөрөнгө оруулалтын тухайд өгөөжийн хэмжээг дараах тэнцлийг ашиглан бодно.

$$FV = PV \times (1+i)^n \quad PV = \frac{FV}{(1+i)^n}$$

$$i = \left( \frac{FV}{PV} \right)^{\frac{1}{n}} - 1$$

(богино хугацааны хөрөнгө оруулалтын хувьд  $n=1$  байна)

Эхний 6 сарын өсөлтийн хувь 5.0 хувь

$$\frac{105}{100} - 1 = 0.05$$

Дараагийн 6 сарын өсөлтийн хувь **9.68 хувь**

$$\frac{170}{155} - 1 = 0.0968$$

Нэг жилийн хугацаанд мөнгөний хэмжээгээр жигнэсэн өгөөжийн хувь нь хамгийн эхний хөрөнгө оруулалт –100.0, 6 сарын дараах хөрөнгө оруулалт –50.0, жилийн эцэст өгөөжийн хамт бий болсон хэмжээ +170.0 мөнгөн урсгалын IRR буюу дискаунт хувь бөгөөд 16.12 хувь юм. Жилийн хоёрдугаар хагаст нэмсэн 50.0 төгрөгөөс шалтгаалан дискаунт хувьд эзлэх хоёрдугаар хагаст хамаарах жин нэгдүгээр хагаст хамаарах жингээс их байна.

Харин цаг хугацаагаар жигнэсэн дискаунт хувьд, нэмсэн нэмэлт хөрөнгө оруулалтын нөлөө тооцогддоггүй, хоёр хагас жилийн өгөөжийн хувь 15.16 хувь байна.

$$\frac{105}{100} \times \frac{170}{155} - 1 = 0.1516$$

Цаг хугацаагаар жигнэсэн өгөөжийн хувь бол геометр дундаж юм. Энэ нь санд (хөрөнгө оруулалт, хадгаламж, зээл) нэмсэн мөнгөний урсгалуудад хамаарах хугацаанд өгөөжийг нийлмэл хүүгээр тооцдог, тухайн хугацаанд нэмсэн мөнгө нь өгөөжийн хувьд нөлөөлдөггүй тул сангийн өсөлтийг харьцуулахад ашиглагддаг.



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХЯНАЛТ 2022 ОНД АНХААРАХ ГОЛ ЧИГЛЭЛҮҮД /ҮРГЭЛЖЛЭЛ/

#### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ОРОЛЦОО БОЛОН ИДЭВХЖИЛ

Компанийн зорилго, стратеги, төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн гол шийдвэрүүдийн талаар хувьцаа эзэмшигчдэдээ мэдээлж, оролцоог хангуулах нь ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын хариуцлага юм. Хувьцаа эзэмшигчдийнхээ үзэл бодлыг харгалзан үзэхийн зэрэгцээ гаргасан шийдвэрүүд нь компанийн ашиг сонирхлын төлөө гэдгийг тэдэнд ойлгуулж, мэдээллээр хангаж байх нь чухал юм.

Хувьцаа эзэмшигчидтэй ил тод байдал, ойлголцолд суурилсан харилцаатай байснаараа бусад хувьцаа эзэмшигчид болон зарим дарамтуудаас ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг хамгаалж, дэмжих давуу талтай байдаг. Хөрөнгийн зах зээл дэх тогтворгүй байдал нэмэгдэж, эрсдэлээс хамгаалах сангууд өсөхийн хэрээр сөрөг үйл ажиллагаа болон хувьцаа эзэмшигчдийн идэвхжил нэмэгдэж байна.

Харилцаа холбооны протокол, хамгийн сүүлийн үеийн хамгаалалт, мэдээлэлтэй байгаа эсэхийг ТУЗ нь санхүүгийн болон хуулийн зөвлөхүүдтэй хамтран шалгах ёстой. Хэрэв компанид идэвхтэн /activist/ хандвал ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь тэдний тавьсан асуудлыг анхаарч үзэх ёстой бөгөөд хамгаалалтын горимд автоматаар шилжиж болохгүй.

#### ТУЗ нь:

- Хувьцаа эзэмшигчдийн үзэл бодлыг сонсож, судлах, тогтвортой харилцааг хөгжүүлэхэд анхаарч, гол хувьцаа эзэмшигчидтэй харилцахад идэвхтэй хяналт тавьж оролцох;
- Уур амьсгалын өөрчлөлт, DEI, корпорацийн соёл зэрэг ESG асуудлуудтай ихэвчлэн холбоотой байдаг компанийн зорилгын талаарх гол хувьцаа эзэмшигчдийн санаа бодлыг ойлгохыг хичээх;
- Компанийнхаа эмзэг байдлыг тодорхойлохын тулд янз бүрийн төрлийн хувьцаа эзэмшигчид компанийн стратеги, засаглалын үйл ажиллагаа зэрэг компанийг хэрхэн харж буй талаар гүйцэтгэх удирдлагатай ярилцах;
- Гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигчийн өөрчлөлтийг хянаж байгаа эсэхийг баталгаажуулах;

- Хамгаалалтын бэлэн байдлын төлөвлөгөөг гүйцэтгэх удирдлагатай ярилцан шинэчлэх, идэвхжүүлэх хэрэгтэй.

#### ХЯМРАЛЫН ҮЕИЙН УДИРДЛАГА

Хямрал нь гүйцэтгэх удирдлагын шударга байдал, итгэл даах байдал, чадавхтай холбоотой үед ТУЗ нь удирдлагын хариу арга хэмжээг авах шаардлагатай болдог. Компанийн гадна болон дотоод үйл явдлаас үүдэлтэй хямралд түргэн шуурхай, найдвартай хариу үйлдэл үзүүлэхэд бэлтгэхийн тулд ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь болзошгүй хямралын эх үүсвэрт анхаарлаа хандуулж, тэдгээрийг арилгах төлөвлөгөө боловсруулах ёстой. Хямралын бэлэн байдлыг ТУЗ болон компанийн соёлд шингээх нь компанид гэнэтийн дарамт шахалт ирэх үед үүсэх хурцадмал байдлыг багасгахад тусална.

Ихэнх тохиолдолд гүйцэтгэх удирдлага хямралыг өдөр бүр шийдвэрлэж, хямралтай холбоотой харилцаа холбоог зохицуулах боловч ТУЗ нь илүү олон удаа хуралдаж, шинэчлэгдэж байх ёстой. ТУЗ (болон гүйцэтгэх удирдлага) нь нөхцөл байдлыг бүрэн харахаас өмнө эерэг үр дүнд хүрсэн мэдэгдэл хийхээс зайлсхийх хэрэгтэй.

Гэсэн хэдий ч гүйцэтгэх удирдлагын ашиг сонирхлын зөрчил, шударга ёсны асуудалд ТУЗ нь ихэвчлэн хараат бус, сонирхлын зөрчилгүй гишүүдээс бүрдсэн тусгай хороогоор дамжуулан илүү идэвхтэй үүрэг гүйцэтгэх ёстой.

#### Хямралд бэлтгэхийн тулд ТУЗ нь:

- Холбогдох гэнэтийн тохиолдлуудын талаар гүйцэтгэх удирдлагатай ярилцах зэргээр компанид гарч болзошгүй эрсдэлд тохирсон бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөгөө байгаа эсэхийг авч үзэх.
- Хямралын үеийн удирдлагын шинэчилсэн төлөвлөгөөний дагуу түүнийг тогтмол үнэлж, зохих хариу арга хэмжээ авахад нь туслах ёстой.
- Мэдээлэл солилцож, ярилцсаны дараа зөвшилцөлд хялбархан хүрч болох, үзэл бодлыг хүндэтгэж, үнэлж, нууцлалыг хамгаалсан ТУЗ-ийн соёлыг дэмждэг засаглалын бүтэц, практикийг хэрэгжүүлснээр хямрал

тохиолдоход үр дүнтэй ажиллах боломжтой гэдгийг баталгаажуулах хэрэгтэй.

### ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ХООРОНДЫН ХАРИЛЦАА БОЛОН ТУЗ–ИЙН СОЁЛ

ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлд хяналт тавьж, чиглэл өгөхийн зэрэгцээ гүйцэтгэх удирдлагад санаа оноогоо хэрэгжүүлж, сайжруулахад чиглүүлж ажиллах ёстой. ТУЗ нь гүйцэтгэх захиралтай баг бөх харилцааг бий болгохын зэрэгцээ бүтээлч удирдамж, шүүмжлэлийг өгөх чадвартай байх шаардлагатай.

Үүнтэй адилаар ТУЗ нь өөрийн гэсэн итгэл, хүндэтгэл, нээлттэй байх соёлыг хөгжүүлэх хэрэгтэй. Зөвшилцөлд хүрэхийн тулд бодитой дүгнэлт хийж, олон янзын үзэл бодлыг илэрхийлж, бодолцох чадвар зайлшгүй шаардлагатай. ТУЗ–ийн бүрэлдэхүүнийг жил бүр дүгнэх, дахин нэр дэвшүүлэх үйл явцад анхаарлаа хандуулах ёстой. ТУЗ–ийн бүрэлдэхүүн, шинэчлэгдсэн байдлыг хувьцаа эзэмшигчид (түүний дотор идэвхтнүүд) нягт нямбай шалгаж байгаа бөгөөд тэд ТУЗ–ийн гишүүдийн мэргэшил, олон талт байдал зэрэгт илүү их анхаарал хандуулдаг. Томоохон мэргэжлийн хөрөнгө оруулагчид ТУЗ–ийн олон талт байдлыг тэргүүлэх чиглэл гэж үзсээр байгаа бөгөөд янз бүрийн

муж улсууд болон Насдак зөвлөлүүдэд олон талт байдлын шаардлагыг тавиад байна.

#### ТУЗ нь:

- Гүйцэтгэх удирдлагад эрх мэдлийг шилжүүлэх, гүйцэтгэлийн хүлээлт болон холбогдох урамшууллын бүтцийг тодорхой болгох;
- Гүйцэтгэх удирдлагад ТУЗ нь өөрийн туршлагаас санал болгох боловч гүйцэтгэх удирдлагыг хянадаг тул бүрэн эрхийн хүрээнд нь тодорхой үйлдлүүдийг даалгах;
- Олон талт байдлыг харгалзан шаардлагатай цаг хугацааны амлалтыг хангаж чадах зохих туршлагатай, өндөр мэргэшсэн гишүүдийг ТУЗ–д авах;
- ТУЗ–ийн нөхөн сэргээх механизм, түүний дотор нас, албан тушаалын хязгаарлалтыг авч үзэж, ТУЗ–ийн гишүүдийн үнэлгээг хянах;
- ТУЗ болон хорооны удирдлагыг үнэлж, удирдах албан тушаал, хорооны гишүүдийн ротацийн асуудлыг авч үзэж, гүйцэтгэх удирдлагад дэмжлэг үзүүлэхийн тулд манлайллыг бий болгох хэрэгтэй.

Эх сурвалж: Harvard Law School Forum on Corporate Governance



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### ОПЕК+ ОЛБОРЛОЛТОО ҮРГЭЛЖЛҮҮЛЭН НЭМЭГДҮҮЛЭХЭЭР ТОХИРОЛЦЖЭЭ.



Сайд нарын түвшинд хийсэн 28 дахь уулзалтаар “ОПЕК+” бүлгийн орнууд нефтийн олборлолтоо урьд нь ярилцаж байсны дагуу 6 дугаар сар хүртэл өдөрт 432 мянган торхоор нэмэгдүүлэхээр тохиролцжээ.

Одоогийн байдлаар нефтийн зах зээлийн тэнцвэрт байдал болон суурь үзүүлэлтүүд нь хэвээр байгааг “ОПЕК+” буюу Нефть экспортлогч улсуудын байгууллагын гишүүн орнууд болон гишүүн бус 11 орны сайд нар онцолсон байна.

2021 онд коронавирусийн цар тахлын үеэр газрын тосны хамгийн том хэрэглэгчид болох БНХАУ, Япон, Энэтхэг, АНУ нь зах зээлийн үнийг буулгахын тулд олборлолтоо нэмэгдүүлэхийг хүссэн ч “ОПЕК+”-ийн орнуудын сайд нар олборлолтыг аажмаар нэмэгдүүлэх анхны төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулахаар болсон. Тус сайд нар сар бүр уулзаж, олборлолтын хэмжээг шийддэг байна.

### БНСУ-Д ИНФЛЯЦЫН ТҮВШИН СҮҮЛИЙН 14 ЖИЛД БАЙГААГҮЙ ӨНДӨР ТҮВШИНД ХҮРЧЭЭ.

БНСУ-ын 4 дүгээр сарын хэрэглээний үнийн индекс /ХҮИ/-ийн мэдээллээс харахад тус улсын инфляц 2008 оноос хойших хамгийн өндөр түвшинд хүрсэн байна. 2022 оны 4 дүгээр сарын ХҮИ нь өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар өссөн нь эдийн засагчдын таамаглаж байснаас 0.4 хувиар өндөр байсан. Уг өсөлтийн шалтгааныг ОХУ, Украины дайны улмаас үүдсэн эрчим хүчний үнийн өсөлт гэж таамаглаж байна. Улмаар 5 дугаар сарын сүүлээр зохион байгуулагдах хурлын үеэр бодлогын хүүг дахин өсгөхөөр төлөвлөж байна.

Тус улсын Төв банк 2021 оны 8 дугаар сараас хойш бодлогын хүүгээ дөрвөн удаа нэмсэн бөгөөд мөнгөний бодлогын зөөлрүүлэх бодлогоос татгалзсан анхны улс болсон.

### ДАЙН ЭХЭЛСНЭЭС ХОЙШ УКРАИН 12.0 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫН ЗЭВСЭГ, САНХҮҮГИЙН ТУСЛАМЖ АВЧЭЭ.



ОХУ Украины дайн эхэлснээс хойш Украин улс 12.0 тэрбум ам.долларын үнэ бүхий зэвсэг, санхүүгийн тусламжийг хүлээн авсан байна. 5 дугаар сарын 05-ны өдөр Польшийн нийслэл Варшав хотноо болсон дээд түвшний хандивлагчдын уулзалтын үеэр Украины Ерөнхий сайд Денис Шмихал нь тууштай дэмжиж байгаа олон улсын хамтын нийгэмлэгт талархал илэрхийлсэн байна. Тус уулзалт нь Польш, Швед, Европын комисс, Европын зөвлөлийн удирдлагууд хамтран зохион байгуулсан ба ОХУ-ын түрэмгийллийн Украины эдийн засаг, хүмүүнлэгийн салбарт үзүүлж буй нөлөөг арилгах зорилготой зохион байгуулагдсан.

Польшийн Ерөнхий сайд Матеуш Моравецкигийн хэлснээр, Украинд зориулж хөрөнгө босгох олон улсын хандивлагчдын хурлаар 6.5 тэрбум ам.доллар цугларчээ. Франц, Финланд, Чех, Хорват болон бусад улс орнууд Украины хүмүүнлэгийн үйлс болон цэргийн үйл ажиллагааг дэмжихийн тулд олон сая еврог өгөхөө амласан байна. Мөн Европын холбооны зүгээс Украины орон гэргүй болсон дүрвэгсдэд 200.0 сая еврогийн тусламж үзүүлэхээ амлажээ. Францын Ерөнхийлөгч Украинд үзүүлэх санхүүгийн тусламжаа 1.7 тэрбум ам.доллаароос 2.0 тэрбум ам.доллар болгон нэмэгдүүлнэ гэдгээ илэрхийлсэн байна.

### ТУРК УЛСЫН ЖИЛИЙН ИНФЛЯЦ 69.97 ХУВЬД ХҮРЧЭЭ.

Турк улсын статистикийн хүрээлэнгийн мэдээлснээр тус улсын жилийн инфляц 69.97 хувь гарчээ. Эрх баригчид инфляцыг бууруулах зорилт тавьж байгаа бөгөөд ажлын үр дүн 2022 оны 5 дугаар сард гарна гэсэн хүлээлттэй байгаагаа Туркийн Ерөнхийлөгч Тайип Эрдоган мэдэгдсэн.

### АМ.ДОЛЛАРТОЙ ХАРЬЦАХ ЮАНИЙН ХАНШИЙГ БУУРУУЛЖЭЭ.

БНХАУ-ын Ардын банк /Төв банк/ юанийн ам.доллартой харьцах ханшийг 6.6332 болгож бууруулсан нь 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс хойших хамгийн доод үзүүлэлт боллоо.



Шанхай хотод үргэлжилж буй хөл хорио, ложистикийн саатал, Бээжинд “Ковид-19”-ийн шинэ дэгдэлт гаргасантай холбогдуулан БНХАУ-ын Төв банк үндэсний валютынхаа ханшийг 4 дүгээр сарын сүүлчээс бууруулж эхэлжээ. 4 дүгээр сарын 26-ны өдрийн юанийн ханш 2015 оны 8 дугаар сарын 13-ны өдрөөс хойших хамгийн их уналтыг үзүүлж, 681 суурь нэгжээр буурсан байна.

БНХАУ-ын эрх баригчид парламентын чуулганы нээлтийн үеэр нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөг танилцуулахдаа 2022 онд юанийн ханшийг оновчтой, тэнцвэртэй түвшинд тогтвортой байлгах, мөн мөнгөний тэнцвэртэй бодлого явуулах зорилт дэвшүүлснээ мэдэгдсэн.

### БИТКОЙНЫ ХАНШ УНАЖЭЭ.

Дэлхийд үнэлгээгээрээ хамгийн томд тооцогдож буй биткойны ханш 2021 оны 11 дүгээр сард түүхэн дээд үзүүлэлтэд /68.0 мянган ам.доллар/ хүрч байсан бол 5 дугаар сарын 7, 8-ны өдрүүдэд биткойны ханш 50 гаруй хувиар унаж 34.0 мянган ам.доллаароос буурсан.

Биткойн нь 640.0 тэрбум ам.долларын үнэлгээтэйгээр криптовалютын зах зээлийн гуравны нэг орчмыг эзэлдэг ба дэлхийн хоёр дахь том криптовалют болох эфириумийн үнэлгээ мөн 5 дугаар сарын эхний долоо хоногт 10 гаруй хувиар буурчээ.

### БНХАУ-ЫН ИНФЛЯЦЫН ТҮВШИН 2.1 ХУВЬТАЙ ГАРЧЭЭ.



БНХАУ-д инфляцын түвшний гол үзүүлэлт болох ХҮИ жилийн дунджаас 2.1 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ. /хотод-2.2%, хөдөө орон нутагт-2.0%/

Хүнсний бүтээгдэхүүний үнэ 1.9 хувиар, хүнсний бус бараа 2.2 хувиар, өргөн хэрэглээний барааны үнэ 3 хувиар, үйлчилгээний үнэ 0.8 хувиар, шинэ ногооны үнэ 24.0 хувиар, жимс жимсгэнэ 14.1 хувиар, өндөг 12.1 хувиар тус тус өссөн бол ХҮИ-ийн гол бүтээгдэхүүний нэг болох гахайн мах 33.3 хувиар буурсан байна. Зам тээвэр, харилцаа холбооны салбарын үйлчилгээний үнэ 6.5 хувиар, боловсролын салбар 2 хувиар, соёл урлаг, үзвэр үйлчилгээний салбар 1.7 хувиар, эрүүл мэндийн үйлчилгээ 0.7 хувиар тус тус өссөн байна.

### АНУ-ЫН ИНФЛЯЦ ӨНДӨР ХЭВЭЭР БАЙНА.


АНУ-ын хүнс, эрчим хүчийг тооцоогүй ХҮИ өмнөх сараас 0.6 хувиар, өмнөх оны мөн үеэс 6.2 хувиар тус тус өсөж, хүлээлтээс илүү өсөлттэй гарсан нь инфляцын дарамтыг нэмэгдүүлж, иргэдийн амьжиргаанд нөлөөлж, улмаар Холбооны нөөцийн сан бодлогын хүүгээ огцом өсгөхөд хүргэв.

Өнгөрсөн сард орон сууц, хоол хүнс, онгоцны тийз, шинэ автомашины үнэ хамгийн ихээр өссөн байна. Үүнээс хамааран ерөнхий ХҮИ өмнөх сараас 0.3 хувиар, өмнөх оны мөн үеэс 8.3 хувиар тус тус өссөн нь сүүлийн арван жилийн хамгийн дээд үзүүлэлт болжээ.

# ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

S&amp;P 500 / ^GSPC/


3,941.48 -32.27 (-0.81%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 / ^N225/


26,748.14 -50.41 (-0.19%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 / ^FTSE/


7,484.35 -29.09 (-0.39%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

11,264.45 -270.45 (-2.35%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

© САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia

